



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШЛАЛ

2015 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 487

Улаанбаатар хот

Г Т


Журам, заавар батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтыг үндэслэн  
ТУШААХ нь:

- “Сэргээн засах тусlamж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Сэргээн засах тусlamж үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Батлагдсан журам зааврыг үйл ажиллагаандaa мөрдөн ажиллахыг сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн нийт байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
- Уг журам, зааврыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны 444 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОЮУНБААТАР



081830

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 12 сарын 11. өдрийн  
487 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн тухай хууль болон түүнтэй холбоотой бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн байгууллагуудад үйлчилүүлэгч төвтэй, үр дүнтэй, оновчтой сэргээн засах тусlamж, үйлчилгээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сэргээн засах тусlamж, үйлчилгээний тасралтгүй, чанартай, тогтвортой байдлыг хангахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 /15.1.6, 15.1.9-өөс бусад/-д заасан улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хамаарна.
- 1.3 Сэргээн засах тусlamж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд нь сэргээн засах тусlamж, үйлчилгээний үндсэн зарчим, үзэл баримтлалыг мөрдөж ажиллана.

### Хоёр. Нэр томьёоны тайлбар

- 2.1 "Сэргээн засах тусlamж, үйлчилгээ" гэж өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилган амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн урт хугацааны тусlamж, үйлчилгээг;
- 2.2 "Эмнэлзүйн сэргээн засах тусlamж, үйлчилгээ" гэж эмнэлгийн байгууллагад суурilan хийгдэх тусlamж, үйлчилгээг;
- 2.3 "Цочмог үеийн сэргээн засах тусlamж, үйлчилгээ" гэж эмнэлэгт суурilsan сэргээн засах тусlamж, үйлчилгээ бөгөөд аливаа өвчний хувьд өвдсөнөөс эхлэн нэг сар хүртэлх хугацааг заана;
- 2.4 "Цочмогдуу үеийн сэргээн засах тусlamж, үйлчилгээ" гэж эмнэлгийн сэргээн засах тасаг нэгжид суурilsan сэргээн засах тусlamж, үйлчилгээ бөгөөд аливаа өвчний хувьд өвдсөнөөс хойших ойролцоогоор 1-6 сар хүртэлх хугацааг заана;

- 2.5 “Архаг буюу тогтвортыхи үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлгийн сэргээн засах тасаг нэгжид суурилсан сэргээн засах тусламж, үйлчилгээ бөгөөд аливаа өвчний хувьд өвдсөнөөс эхлэн ойролцоогоор 6 сараас дээш хугацааг заана;
- 2.6 “Хэвтүүлэн эмчлэх сэргээн засах тусламж үйлчилгээ” гэж үндсэн өвчин эмгэг болон түүний үр дагавраас үүсэх үйл ажиллагааны чадвар алдагдлыг сэргээн засах зорилгоор эмнэлэгт суурилсан сэргээн засах тусламж, үйлчилгээний хэлбэрийг
- 2.7 “Өдрийн сэргээн засах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлэгт хонуулахгүйгээр өдрөөр эмчилгээ, үйлчилгээ хийж явуулах тодорхой нөхцөлийг хангасан эмнэлгийн байгууллагад суурилсан сэргээн засах тусламж, үйлчилгээний хэлбэрийг;
- 2.8 “Амбулаторийн сэргээн засах тусламж, үйлчилгээ” гэж амбулаторийн нөхцөлд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний хэлбэрийг;
- 2.9 “Гэрийн сэргээн засах тусламж, үйлчилгээ” гэж гэртээ гарсан эмчлүүлэгчид сэргээн засах мэргэжлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний хэлбэрийг;
- 2.10 “Сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас” гэж өвчтөний биеийн бүтэц үйл ажиллагаа болон өдөр тутмын амьдралын үйл ажиллагааны чадвар алдагдлын түвшин, сэргээн засах эмчилгээний үр дүнг үнэлэх зорилгоор сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх бүх төрлийн эрүүл мэндийн байгууллагуудад ашиглах үнэлгээний хуудсыг;
- 2.11 “Сэргээн засах эмчилгээний өрөнхий төлөвлөгөө” гэж өвчин эмгэг, гэмтлийн улмаас алдагдсан биеийн бүтэц үйл ажиллагааны болон өдөр тутмын амьдралын үйл ажиллагааны чадварыг өвчтөн хувь хүн, түүний гэр бүлийн хүсэл, хэрэгцээнд тулгуурлан боломжит дээд түвшинд хүргэх зорилгоор хийгдэх сэргээн засах тусламж, үйлчилгээний төлөвлөгөөг.

#### **Гурав. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго**

Сэргээн засах тусламж, үйлчилгээний зорилго нь чадвар алдалттай болсон болон болох эрсдэлтэй хүмүүсийн бие, сэтгэц, нийгмийн харилцаанд дасан зохицох хэрэгцээт мэдлэг чадварыг бий болгосноор тухайн хүний амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино. Сэргээн засах тусламж, үйлчилгээ нь дараах өргөн хүрээтэй зорилтуудыг хангахад чиглэсэн байна:

- 3.1 Бие эрхтний хэвийн үйл ажиллагааг алдагдахаас урьдчилан сэргийлэх;
- 3.2 Бие эрхтний хэвийн үйл ажиллагааг алдагдах хурдыг удаашруулах;
- 3.3 Бие эрхтний алдагдсан үйл ажиллагааг сайжруулах, боломжит дээд хэмжээнд хүртэл нь эргэн сэргээх;
- 3.4 Одоо байгаа үйл ажиллагааг нь хадгалах;
- 3.5 Бие эрхтний алдагдсан үйл ажиллагааг орлуулах;

## **Дөрөв. Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх зарчим**

Хүн өөрчлөгдсөн нөхцөл байдалд дасан зохицох, алдагдсан чадвараа хэвийн болон боломжит дээд хэмжээнд хүргэхэд "суралцах" үйл явцад тулгуурлаж дараах зарчмуудад үндэслэнэ.

- 4.1 Үйлчлүүлэгч бүрийн хувийн онцлогт тохируулсан байх;
- 4.2 Зорилгодоо хүрэх дэс дараалал, үе шаттай байх;
- 4.3 Цогц бүрдэл байх;
- 4.4 Багийн хамтын ажиллагаатай байх;
- 4.5 Гэр бүл, хамт олны оролцоог хангасан байх;
- 4.6 Сэргээн засалт нь өвдсөн цаг мөчөөс эхэлж, нийгмийн харилцаа бүрэн; боломжит дээд хэмжээнд сэргэх хүртэл тасралтгүй байх;

**Тав. Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаа**

### **5.1 Нийтлэг үүрэг, үйл ажиллагаа**

5.1.1 Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах тусlamж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийг хүлээн авах, бүртгэх, нэгтгэн мэдээлэх, тайлгахаа, тасралтгүй хянах, эмнэлгийн байгууллагын хооронд шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

5.1.2 Эрүүл мэндийн байгууллага нь тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас болон эмчилгээний ерөнхий төлөвлөгөөг хөтөлж, эмнэлгийн байгууллага хоорондын бүртгэл болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын мэдээллийн нэгдсэн санг бий болгож ажиллана.

5.1.3 Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засалч эмч, сувилагч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтнүүдээ эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтад тогтмол хамруулж, мэдлэг ур чадвар, хандлагыг дээшлүүлэхэд санаачлага, идэвх чармайлт гаргаж ажиллана.

5.1.4 Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн гишүүдэд үйл ажиллагааны чадвар алдагдал, түүнд хүргэх эрсдэлд хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж ажиллана.

5.1.5 Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах багийн тусlamж, үйлчилгээний үндсэн зарчим, үзэл баримтлалыг хэрэгжүүлж, шаардлагатай хүний нөөцийг зөв зохистой бүрдүүлж ажиллана.

5.1.6 Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах тусlamж үйлчилгээнд шаардлагатай орчин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрдүүлж, батлагдсан стандарт, эмчилгээний заавар, удирдамжийг мөрдөж ажиллана.

## **5.2 Өвөрмөц үүрэг, үйл ажиллагаа**

5.2.1 Өрх, сумын эрүүл мэндийн төвд сэргээн засах тусlamж үйлчилгээг гэрийн болон өдрийн хэлбэрээр үзүүлж, шаардлагатай тохиолдолд эмчилгээг дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагуудад илгээх бичгээр шилжүүлнэ.

5.2.2 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь олон нийтэд түшиглэсэн сэргээн засах тусlamж үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамж, аргачлал, зааврын дагуу үзүүлнэ.

5.2.3 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь сэргээн засах тусlamжийн чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаж, тусlamж үйлчилгээ үзүүлэх ур чадварыг эзэмшсэн байна.

5.2.4 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, бүсийн оношилгоо эмчилгээний төвд сэргээн засах тусlamж үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн болон өдрийн хэлбэрээр үзүүлж, эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагатай бол зохих шатны эрүүл мэндийн байгууллагад илгээх бичгээр шилжүүлнэ.

5.2.5 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сувилал, бүсийн оношилгоо эмчилгээний төв нь сэргээн засалч эмч, сэргээн засах чиглэлийн мэргэшсэн багийн тусlamж үйлчилгээг үзүүлнэ.

5.2.6 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь тухайн чиглэлүүдээр улсын хэмжээнд сэргээн засах тусlamж, үйлчилгээний лавлагаа, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүрэгтэй ажиллана.

5.2.7 Энэ үүргийн хүрээнд бусад эрүүл мэндийн байгууллагын сэргээн засах тусlamж, үйлчилгээний олон мэргэжилтний багийг сургах, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

5.2.8 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь тухайн чиглэлүүдээр сэргээн засах тусlamж, үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн болон өдрийн сэргээн засах тусlamж, үйлчилгээг зохион байгуулж ажиллана.

5.2.9 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх өвчин эмгэгийн нэр төрлийн жагсаалт, хөтөлбөр, оношилгоо, эмчилгээний удирдамжтай, түүнийгээ мөрдөж ажиллана.

5.2.10 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал нь батлагдсан стандарт, удирдамж, бусад хууль эрх зүйн баримтыг мөрдлөг болгон сэргээн засах тусlamж үйлчилгээг үзүүлнэ

## **Зургаа. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх үе шат**

Эмнэлзүйн сэргээн засах тусламж, үйлчилгээг дараах үе шатаар тасралтгүй үзүүлнэ.

- 6.1 **Цочмог үе:** Өвчний цочмог буюу эхэн үе, амьдралын чухал эрхтний үйл ажиллагааг дэмжих, өндөр хараа хяналтад хэвтрийн дэглэмээс үүдэлтэй “үл ашиглах хам шинж”-ийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх, биеийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн эрт үеийн сэргээн засалт;
- 6.2 **Цочмогдуу үе:** Өвчний даамжралтыг зогсоох, биеийн үйл ажиллагааны чадвар, өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг сайжруулж сэргээхэд чиглэгдсэн илүү эрчимтэй сэргээн засалтын буюу хамгийн боломжит түвшинд хүргэх “идэвхтэй” үе;
- 6.3 **Архаг үе:** Өөрчлөгдсөн нөхцөл байдалдаа дасан зохицох, өдөр тутмын амьдралын үйл ажиллагааны дахин сэргэсэн чадварыг тогтоон барих, хэвийн байдалд ойртуулахад чиглэгдсэн амьдралын зорилгот үйл явцад “суралцах” үе;

## **Долоо. Сэргээн засах тусламж үйлчилгээний төрөл**

Сэргээн засах эмчилгээ нь дараах үндсэн төрлүүдтэй байна.

- 7.1 Сэргээн засалч эмчийн тусламж, үйлчилгээ
  - 7.1.1 Үзлэг, оношилгоо, үнэлгээ, зөвлөгөө
  - 7.1.2 Эмийн эмчилгээ
- 7.2. Сэргээн засах чиглэлийн мэргэжилтний үзлэг, үнэлгээ, зөвлөгөө
  - 7.2.1 Бие бялдар засал
    - о Хөдөлгөөн засал эмчилгээ
    - о Физик эмчилгээ
  - 7.2.2 Хөдөлмөр засал
    - о Үйл ажиллагааны хөдөлмөр засал
    - о Харилцах чадварын хөдөлмөр засал
    - о Танин мэдэхүйн сэргээн засах эмчилгээ
    - о Сэтгэл засал эмчилгээ
  - 7.2.3 Хэл, яриа засал
  - 7.2.4 Протез, ортез, туслах хэрэгслийн засал
- 7.3 Нийгэм, хамт олонд тулгуурласан сэргээн засах тусламж үйлчилгээ
- 7.4 Сэргээн засах сувилахуйн тусламж, үйлчилгээ
- 7.5 Эрүүл мэндийн боловсрол

## **Найм. Сэргээн засах тусламж, үйлчилгээний оношилгоо, үнэлгээ**

- 8.1 Сэргээн засах тусламж, үйлчилгээний оношилгоо, үнэлгээний аргуудад дараах зарчмуудыг баримтална.
  - 7.1.1 Олон улсын хэмжээнд нийтлэг ашиглагддаг байх
  - 7.1.2 Өдөр тутмын практикт ашиглагддаг оношилгооны арга байх
  - 7.1.3 Найдвартай байдал болон хүчин төгөлдөр байдал нь баталгаажсан байх

- 8.2 Сэргээн засах тусламж үйлчилгээний оношилгоо үнэлгээнд дараах аргуудыг ашиглана.
- 7.2.1 Эмнэлзүйн анагаах ухааны өвчний түүхийн асуумж, биеийн үзлэг, цус, шээс, биохимиийн лабораторийн шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг зэрэг үйл ажиллагааны багажийн шинжилгээ, рентген, ЭХО, СТ, MRI, MRA зэрэг дүрсийн шинжилгээний аргууд
- 7.2.2 Мэдрэл булчингийн бүтэц зүйн шинжилгээ, булчингийн цахилгаан бичлэг зэрэг электрофизиологийн шинжилгээ, алхааны анализ, мэдрэл сэтгэцийн шинжилгээ, хэл ярианы үйл ажиллагааны шинжилгээ зэрэг сэргээн засах анагаах ухааны тусгайлсан үзлэг шинжилгээ, үнэлгээний аргууд
- 8.3 Сэргээн засах тусламж үйлчилгээнд дээрх аргуудыг ашиглан дараах үзүүлэлтүүдийг тодорхойлно.
- 8.3.1 Биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын түвшин
- 8.3.2 Биеийн үйл ажиллагааны хязгаарлагдмал байдлыг
- 8.3.3 Чадвар алдагдлын түвшин буюу зорилгот үйлийн хязгаарлалт
- 8.3.4 Нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдлыг
- 8.3.5 Орчны болон хувь хүний хүчин зүйл
- 8.3.6 Амьдралын чанарын түвшин

#### **Ес. Сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнг тооцох**

Оношилгоо, үнэлгээний үнэн зөв мэдээлэл, сэргээн засах тусламж, үйлчилгээний арга хэлбэрийн оновчтой сонголт, нотолгоонд суурилсан эмнэлгийн сэргээн засах тусламж, үйлчилгээ, нийгэм, хамт олон, гэр бүлийн дэмжлэгт үйл ажиллагаанаас гарах үр дүнг доорх үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр тооцно.

1. Үйл ажиллагааны чадвар сайжирсан байдал
2. Зорилгот үйлийн чадвар сайжирсан байдал
3. Нийгмийн оролцоо сайжирсан байдал
4. Амьдралын чанар сайжирсан байдал
5. Үндсэн эмгэгийн эмчлэгдсэн байдал
6. Хүндрэл, дахилтын байдал

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 10 сарын 11. өдрийн  
487 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

УХА0033 9087443

## СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

### Нэг. Нийтлэг зүйлс

- 1.1 Эрүүл мэндийн байгууллагуудад сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд энэхүү зааврыг мөрдөнө.
- 1.2 Сэргээн засах тусlamж, үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 /15.1.6, 15.1.9-өөс бусад/-д заасан эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй сэргээн засах чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.
- 1.3 Сэргээн засах тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурлан шаардлагатай чиглэлээр олон мэргэжлийн багийн тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.4 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн байгууллагууд нь тусlamж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг анхан шатны бүртгэлийн батлагдсан маягтуудад бүртгэж, сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас, ерөнхий төлөвлөгөөг хөтлөх бөгөөд эдгээр бичиг баримт нь байгууллагын болон иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авах үндсэн баримт болно.

### Хоёр. Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалт

- 2.1 Өвчин, эмгэг, гэмтлийг анааах ухааны үүднээс оношилж, өвчний явц тавиланг үнэлэх, түүнд тохирсон сэргээн засах эмчилгээний жор, үндсэн болон хавсарсан өвчний хүндрэл, дахилт, хоёрдогч эмгэг үүсэх зэргээс урьдчилан сэргийлсэн эмчилгээний төлөвлөгөөг зохиоход сэргээн засалч эмч тусlamж, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
- 2.2 Сэргээн засалч эмч нь сэргээн засах тусlamж, үйлчилгээ шаардлагатай өвчтөний үзлэг оношилгоо, үнэлгээ, төлөвлөгөөг сэргээн засах чиглэлийн бусад мэргэжилтний багийн хамтаар шийдвэрлэнэ.
- 2.3 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгчид өвчний тавилан, явцын талаар тайлбарлаж, сэргээн засах эмчилгээний агуулга, ач холбогдлын талаар таниулж, зөвшөөрөл авч байна.
- 2.4 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь сэргээн засах эмчилгээний зорилго, зорилтыг төлөвлөхөд өвчтөн тэдний гэр бүлийг оролцуулж шийдвэрлэж байна.
- 2.5 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгч бүрийн хувийн онцлогт тохирсон сэргээн засах эмчилгээний төлөвлөгөөг зохиож, түүний дагуу тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

- 2.6 Сэргээн засах эмчилгээний үр дүнг тодорхой хугацаанд үнэлж, шаардлагатай бол төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, засаж сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.7 Сэргээн засалч эмч, мэргэжилтнүүд нь сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлсэн өвчтөнг дараагийн эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэхдээ сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас, эмчилгээний ерөнхий төлөвлөгөөг хөтлөн хүлээлгэн өгч, мэдээллийг хамтран ашиглана.
- 2.8 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагууд нь үйлчлүүлэгчийн оношилгоо эмчилгээнд тогтсон нэг ижил үнэлгээний шалгуурыг ашиглаж үнэлгээг хийнэ.
- 2.9 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагууд нь сэргээн засах тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардлагатай бүртгэл судалгааг тогтмол хийнэ.
- 2.10 Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагууд нь сэргээн засах тусlamж үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх шалгууртай байна.

#### **Гурав. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний үйл явцын дараалал**

Сэргээн засах тусlamж, үйлчилгээний үйл явц нь дараах дарааллын дагуу тасралтгүй үргэлжилж явагдана.

- 3.1 Сэргээн засалч эмчийн үзлэг, оношилгоо, үнэлгээ, зөвлөгөө
- 3.2 Сэргээн засах чиглэлийн мэргэжилтний үзлэг, үнэлгээ
- 3.3 Сэргээн засах багийн зөвлөгөөн
- 3.4 Сэргээн засах эмчилгээний төлөвлөгөө
- 3.5 Хүн бүрт тохирсон хөтөлбөрийн дагуу сэргээн засах эмчилгээ
- 3.6 Эмчилгээний үр дүнгийн хяналт
- 3.7 Сэргээн засах багийн давтан үнэлгээ

#### **Дөрөв. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний хэлбэр, хугацаа, давтамж**

- 4.1 Физик эмчилгээнээс бусад сэргээн засах эмчилгээний нэг удаагийн хамгийн доод хугацааг 20 минутаас доошгүй байхаар зохион байгуулна.
- 4.2 Сэргээн засалч эмчийн бичсэн эмчилгээний жорын дагуу нэг удаад хоёроос дээш нэр төрлийн эмчилгээг сонгож нэг багц болгож үзүүлнэ.
- 4.3 Хэвтүүлэн эмчлэх сэргээн засах тусlamж үйлчилгээг өдөрт 6 хүртэлх цагаар, 7-оос доошгүй хоногоор эрчимтэй үзүүлэхээр зохион байгуулна.
- 4.4 Өдрийн сэргээн засах тусlamж үйлчилгээг өдөрт 4 хүртэлх цагаар, 7-оос доошгүй хоногоор шаардлагатай үед үзүүлэхээр зохион байгуулна.
- 4.5 Амбулаторийн сэргээн засах тусlamж үйлчилгээг нэг удаад 1 хүртэлх цагаар тодорхой үргэлжлэх хугацаатай шаардлагатай үед үзүүлэхээр зохион байгуулна.
- 4.6 Гэрийн сэргээн засах тусlamж үйлчилгээг нэг удаад 2 хүртэлх цагаар нийтдээ 7-оос доошгүй хоногийн үргэлжлэх хугацаатай шаардлагатай үед үзүүлэхээр зохион байгуулна.

Тав. Сэргээн засах тусламж үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо, эмчилгээний нэр төрлийн жагсаалт

5.1 Сэргээн засах тусламж үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо үнэлгээний сорилын нэр төрөл

Д/д	Оношилгоо үнэлгээний ерөнхий агуулга	Тусгай агуулга	ӨЭМТ, СТЭМТ, СДЭ	Клиник, НЭ, Сувилап	БОЭТ, ТМТ, ТЭ
1	Өвдөлтийн үнэлгээ:	Өвдөлтийг тодорхойлох тоон хэмжээст үнэлгээ NAS/ Өвдөлтийн бусад нарийвчилсан стандарт асуумж, үнэлгээ /MPQ/	○	○	○
2	Үений далайцын үнэлгээ:	Гониометрийн үнэлгээ Үений далайцын кинематик Үнэлгээ/хөдөлгөөний анализ хийх програм ашиглах/	○	○	○
3	Булчингийн хүчиний үнэлгээ:	Изорметрик сорил /MMT/ Динамометр багажийн сорил	○	○	○
4	Бүх биеийн тэсвэрлэх чадварын үнэлгээ	Амьсгалын хийн анализ Хөдөлгөөний ачаалалтай сорил Алхааны сорил (12 минут, 6 минутын сорил)	○	○	○
5	Өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ:	Боргийн сорил Бартелийн индекс (BI) Багажтай өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ (IADL), Катз Үйл ажиллагааны хараат бус байдал (FIM)	○	○	○
6	Өвөрмөц болон тусгай сорил үнэлгээ:	Яс булчин, тулгуур эрхтэний үйл ажиллагааны үнэлгээ:	Мэдрэл, яс булчингийн тогтолцооны хэвийн өсөлт хөгжил Морфометрийн үнэлгээ Рефлекс	○	○

	Мэдрэхүй	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Тэнцвэр: Статик (Суугаа, Зогсоо)	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Тэнцвэр: Динамик	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Эмгэг төрх байрлал	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Алхаа анализ: Ажиллалт, Кинетик	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Алхааны анализ: Кинематик	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Энерги зарцуулалтын анализ	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Ортез протезийн үнэлгээ	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Яс булчин, тулгуур эрхтэний бусад өвөрмөц сориллууд	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Зурхий цохиилт, судасны лугшилт тодорхойлох	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Амьсгалын тоо	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Артерийн даралт	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Захын цусны хүчилтөрөгчийн ханамж	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Хийн анализ	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Амьсгалын үйл ажиллагааны сорилт Дасгалын эрчим тодорхойлох	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Алхааны сорилт	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Ачаалал тодорхойлох сорил /Bruce/ Зурх том судасны үйл ажиллаганы бусад өвөрмөц үнэлгээ	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Булчингийн тонус	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Булчингийн цахилгаан бичлэг	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Саа саажилт	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Байрлалын хяналт	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
	Эмгэг төрх байрлал	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
7				
8	Тархи мэдрэлийн үйл ажиллагааны үнэлгээ:			

	Эмгэг алхaa (Кинематик, Кинетик)	<input type="radio"/>
	Үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн үнэлгээ (Зорилгот үйлдэл)	<input type="radio"/>
	Харааны алдагдал	<input type="radio"/>
	Хэл залгиурын үйл ажиллагаа	<input type="radio"/>
	Зан үйл	<input type="radio"/>
	Танин мэдэхүйн үйл ажиллагаа	<input type="radio"/>
	Товчипсон уг: ΘЭМТ: өрхийн эрүүл мэндийн төв; СТЭМТ: сүм тоогтоны эрүүл мэндийн төв; СДЭ: сүм дундын эмнэлэг; НЭ: нэгдсэн эмнэлэг; БОЭТ: бусийн оношилгоо эмчилгээний төв; ТЭ: төв эмнэлэг; ТМТ: тусгай мэргэжлийн төв; ММТ: Manual Muscle Test; VAS:Visual Analog Scale; MPQ: McGill Pain Questionnaire; BI: Barthel Index; FIM: Functional Independence Measure; ADL: Activities of Daily Living; IADL: Instrumental activities of daily living;	

## 5.2 Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх эмчилгээний нэр төрөл

Д/А	Сэргээн засах эмчилгээний төрөл	ΘЭМТ, СТЭМТ, СДЭ	Клиник, НЭ, Сувилал	Лохморүү耶 (0-1 cap)	Лохморүү耶 (1-6 cap)	Лохморүү耶 (6 capaac)	Лохморүү耶 (0-1 cap)	Лохморүү耶 (1-6 cap)	Лохморүү耶 (6 capaac)	Лохморүү耶 (0-1 cap)	Лохморүү耶 (1-6 cap)	Лохморүү耶 (6 capaac)	Лохморүү耶 (0-1 cap)	Лохморүү耶 (1-6 cap)	Лохморүү耶 (6 capaac)	Лохморүү耶 (0-1 cap)	Лохморүү耶 (1-6 cap)	Лохморүү耶 (6 capaac)	Лохморүү耶 (0-1 cap)	Лохморүү耶 (1-6 cap)	Лохморүү耶 (6 capaac)		
		ΘЭМТ, СТЭМТ, СДЭ	Клиник, НЭ, Сувилал	БОЭТ, ТМТ, ТЭ																			
1	Өндөр хараа хянапланд хэвтрийн дэглэмээс үүдэлтэй үл ашиглах хам шинжийн хундрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээ			<input type="radio"/>																			
2	Төлөвлөгөөт мэс застлын өмнө, хойно үүсч болох хундрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээ				<input type="radio"/>																		
3	Үений далайц сайжруулах дасгал эмчилгээ			<input type="radio"/>																			

	(идэвхитэй болон идэвхигүй далайцын дасгал, сунгарт дасгал, уений мобилизаци)		
4	Булчингийн хүч сайжруулах дасгал эмчилгээ (изометрик, икотоник, изокинетик, нээлттэй болон хаалттай кинетик дасгал)	○ ○ ○ ○ ○ ○	
5	Зохицолт хөдөлгөөн (координаци) сайжруулах дасгал эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
6	Булчинг хөдөлгөөнд эргэн сургах (мэдрэл булчинг дэмжих эмчилгээ, булчиний цахилгаан биофеедбак)	○ ○ ○ ○ ○ ○	
7	Эмчилгээний дасгал (Уильямс, Френкел, Кодман, Буэргер-Аллены дасгал)	○ ○ ○ ○ ○ ○	
8	Биийн тэсвэрлэх чадварыг сайжруулах дасгал эмчилгээ (аэробик болон анаэробик дасгал)	○ ○ ○ ○ ○ ○	
9	Тэнцвэр сайжруулах (статик, динамик) дасгал эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
10	Эмгэг төрх байдал засах дасгал эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
11	Эмгэг алхaa засах дасгал эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
12	Иллэг, гар засал	○ ○ ○ ○ ○ ○	
13	Дулаан эмчилгээ (халуун жин, парафин, хэт улаан туяа, хэт богино долгио, ботгино долгионы болон хэт авиян эмчилгээ)	○ ○ ○ ○ ○ ○	
14	Хүйтэн жин	○ ○ ○ ○ ○ ○	
15	Хэт ягаан туяа эмчилгээ (халуун хйтэн кварц)	○ ○ ○ ○ ○ ○	
16	Лазер эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
17	Татлагтаа эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
18	Усан эмчилгээ	○ ○ ○ ○ ○ ○	
19	Цахилгаан эмчилгээ (эмчилгээний цахилгаан цочруул: TES)	○ ○ ○ ○ ○ ○	
20	Цахилгаан эмчилгээ (үйл ажиллагааны цахилгаан цочруул: FES)	○ ○ ○ ○ ○ ○	



41	Эмнэлгээс гарах төлөвлөгөө боловсруулах													
42	Гэр бүл, асран хамгаалагчийн оролцоо, дэмжлэгийг бий болгох													
	Товчилсон уг: ΘЭМТ: өрхийн эрүүл мэндийн төв; СТЭМТ: сүм тосгоны эрүүл мэндийн төв; СДЭ: сүм дундын эмнэлэг; НЭ: нэгдсэн эмнэлэг; БОЭТ: бусийн оншилгоо эмчилгээний төв; ТЭ: төв эмнэлэг; ТМТ: тусгай мэргэжлийн төв; TES:therapeutic electrical stimulation; FES:functional electrical stimulation; TENs:transcutaneous electrical nerve stimulation;	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○

## СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Эмнэлгийн байгууллага	<input type="checkbox"/> 15.1-1 <input type="checkbox"/> 15.1-2 <input type="checkbox"/> 15.1-3 <input type="checkbox"/> 15.1-4 <input type="checkbox"/> 15.1-5 <input type="checkbox"/> 15.1-7 <input type="checkbox"/> 15.1-8 <input type="checkbox"/> 15.1-10 <input type="checkbox"/> 15.1-11 <input type="checkbox"/> 15.1-12												
Эмнэлгийн нэр													
Бүртгэсэн огноо	он	сар	өдөр	хөтөлсөн:				<input type="checkbox"/> Dr	<input type="checkbox"/> Ns	<input type="checkbox"/> PT	<input type="checkbox"/> OT		
Өвчтөний нэр/ID				ID.....	төрсөн: .....он.....сар.....өдөр		нас:		<input type="checkbox"/> эр	<input type="checkbox"/> эм			
Нийгмийн байдал	гэр бүл:	<input type="checkbox"/> гэрлэсэн	<input type="checkbox"/> үгүй	боловсрол:		<input type="checkbox"/> дээд	<input type="checkbox"/> дунд	<input type="checkbox"/> үгүй	ажил эрхлэлт:		<input type="checkbox"/> ажилтай	<input type="checkbox"/> үгүй	
Гэрийн хаяг									утас:				
Эмнэлэгт	хэвтсэн: .....он.....сар.....өдөр			гарсан: .....он.....сар.....өдөр						...ор хоног			
Өвчин эхэлсэн огноо	.....он.....сар.....өдөр												
Өвчиний онош													
Хавсарсан суурь өвчин ба эрэдэлт хүчин зүйл	<input type="checkbox"/> гипертензи		<input type="checkbox"/> гиперлипидеми										
	<input type="checkbox"/> диабет		<input type="checkbox"/> таргалалт										
	<input type="checkbox"/> бөөрний архаг өвчин		<input type="checkbox"/> бусад				<input type="checkbox"/> тамхи	<input type="checkbox"/> архи	<input type="checkbox"/> удамшил				
Үйл ажиллагааны чадвар алдагдлын													
Биений бүтэц үйл ажиллагааны алдагдал (давхардах болно)	<input type="checkbox"/> оюун санаа:		<input type="checkbox"/> глазков оноо:										
	<input type="checkbox"/> танин мэдэхүйн алдагдал:		<input type="checkbox"/> ой тогтоолтын эмгэг						<input type="checkbox"/> анхаарал суралын эмгэг				
	<input type="checkbox"/> хөдөлгөөний алдагдал:		<input type="checkbox"/> гүйцэтгэлийн үйл ажиллагааны эмгэг						<input type="checkbox"/> нийгмийн зан үйлийн эмгэг				
	<input type="checkbox"/> мэдрэхүйн алдагдал:		<input type="checkbox"/> хүрэлцэх		<input type="checkbox"/> дулаан				<input type="checkbox"/> өвдөлт VAS: MPQ:				
	<input type="checkbox"/> хэл ярианы эмгэг:		<input type="checkbox"/> авиа (сонсголгүйдэл)						<input type="checkbox"/> цусны эргэлтын тогтолцооны алдагдал				
	<input type="checkbox"/> залгиурын алдагдал		<input type="checkbox"/> амьсгалын эрхтэнний алдагдал						<input type="checkbox"/> ялгаруулах эрхтний алдагдал				
	<input type="checkbox"/> харааны алдагдал		<input type="checkbox"/> ROM: (										
	<input type="checkbox"/> алхааны эмгэг		<input type="checkbox"/> MMT: (										
	<input type="checkbox"/> үений далайц хязгаарлагдал:		<input type="checkbox"/> бусад (										
	<input type="checkbox"/> булчингийн хүчиний суртал:												
<input type="checkbox"/> цооролт													
Зорилгот үйл (Хэвтрин дэглэм барих шалтгаан, эрсдлийн талаар):  Өдөр тутмын үйл ажиллагаа (ADL):	үндсэн хөдөлгөөн	<input type="checkbox"/> хөрвэх:	<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй								
		<input type="checkbox"/> ёндийх:	<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй								
		<input type="checkbox"/> суух:	<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй								
		<input type="checkbox"/> босох:	<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй								
		<input type="checkbox"/> зогсох:	<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй								
				<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй							
				<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй							
				<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй							
				<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй							
				<input type="checkbox"/> бие даасан	<input type="checkbox"/> хагас дэмжлэгтэй	<input type="checkbox"/> бүрэн дэмжлэгтэй							
Зорилгот үйлийн хязгаарлалт Өдөр тутмын үйл ажиллагаа (Бартелийн индекс)	Хооллох		<input type="checkbox"/> 10	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0								
	Шилжих		<input type="checkbox"/> 15	<input type="checkbox"/> 10	←хяналтан дор								
	Суух боловч шилжиж чадахгүй→		<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0	<input type="checkbox"/> 0								
	Угаалга		<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0	<input type="checkbox"/> 0								
	Бие засах		<input type="checkbox"/> 10	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0								
	Усанд орох		<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0	<input type="checkbox"/> 0								
	Тэгш газар алхах		<input type="checkbox"/> 15	<input type="checkbox"/> 10	←алхах хэрэгсэл								
	Тэргэнцэр жолоодох боломжтой		→	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0								
	Шатаар өгсөх уруудах		<input type="checkbox"/> 10	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0								
	Хувцаслах		<input type="checkbox"/> 10	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0								
Етгэнээ хянах		<input type="checkbox"/> 10	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0									
Шинэгэнээ хянах		<input type="checkbox"/> 10	<input type="checkbox"/> 5	<input type="checkbox"/> 0									
Нийт(0~100 оноо)				ОНОО									
Харилцааны чадвар		ОЙЛГОЛТ											
		ИЛЭРХИЙЛЭЛТ											
Нийгмийн оролцооны хязгарагдмал байдал	<input type="checkbox"/> ажил:		<input type="checkbox"/> ажилгүй		<input type="checkbox"/> өвчиний улмаас ажилгүй болсон		<input type="checkbox"/> өвчиний улмаас чөлөөтэй						
	<input type="checkbox"/> мэргэжил(төрөл агуулга):												
	<input type="checkbox"/> эдийн засгийн байдал:												
	<input type="checkbox"/> оролцоо (агуулга, давтамж):												
Сэтгэл зүй	<input type="checkbox"/> амралт зугса(агуулга давтамж):												
	<input type="checkbox"/> сэтгэл гутрал:												
	<input type="checkbox"/> сэтгэл санааны цочрол:												
Орчин	<input type="checkbox"/> бусад:												
	<input type="checkbox"/> хамт амьдардаг гэр бүлийн байдал												
	<input type="checkbox"/> төрөл терөгсөд												
	<input type="checkbox"/> амьдрач буй орчин												
<input type="checkbox"/> ашигладаг тээврийн хэрэгсэл													

## СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

сэргээн засалтын үе шат	<input type="checkbox"/> цочмог <input type="checkbox"/> цочмогдуу <input type="checkbox"/> архаг ( урт хугацаны )		
сэргээн засах эмчилгээний хэлбэр	<input type="checkbox"/> хэвтүүлэн эмчлэх <input type="checkbox"/> амбулаторийн <input type="checkbox"/> өдрийн <input type="checkbox"/> гэрийн <input type="checkbox"/> бусад ( )		
сэргээн засалт эхэлсэн огноо	.....он.....сар.....өдөр	үргэлжлэх хугацаа:	<input type="checkbox"/> 2 долоо хоног <input type="checkbox"/> 1 сар <input type="checkbox"/> 2 сар <input type="checkbox"/> 3 сар
сэргээн засалтын зорилго			
богино хугацааны зорилт	.....хоног, сарын дараа:	хувь хүний хүсэл : гэр бүлийн хүсэл :	
урт хугацааны зорилт	.....сарын дараа:	хувь хүний хүсэл : гэр бүлийн хүсэл :	
эмчилгээ хийх хэсэг	<input type="checkbox"/> хүзүү <input type="checkbox"/> цээж нуруу <input type="checkbox"/> ууц нуруу <input type="checkbox"/> мөрний бүслүүр <input type="checkbox"/> дээд мөч <input type="checkbox"/> сарвуу <input type="checkbox"/> доод мөч <input type="checkbox"/> аарцгийн бүслүүр <input type="checkbox"/> түнхний ўе <input type="checkbox"/> гүя <input type="checkbox"/> өвдөгний ўе <input type="checkbox"/> шилбэ <input type="checkbox"/> шагайн ўе, тавхай <input type="checkbox"/> дөрвөн мөч <input type="checkbox"/> их бие <input type="checkbox"/> бусад ( тархи, зүрх, уушиг гэх мэт )		
сэргээн засах эмчилгээний төрөл, агуулга	<input type="checkbox"/> эрт үеийн сэргээн засал: <input type="checkbox"/> гар хөлийн хөдөлгөөн <input type="checkbox"/> суулгах <input type="checkbox"/> босгох <input type="checkbox"/> алхуулах <input type="checkbox"/> залгуулах <input type="checkbox"/> хооллох <input type="checkbox"/> биесийн байрлал солих <input type="checkbox"/> хэл ярианы <input type="checkbox"/> өөртөө үйлчлэх <input type="checkbox"/> бусад:( )		
	<input type="checkbox"/> бие бялдар хөдөлгөөн засал: <input type="checkbox"/> үений далаачын дасгал <input type="checkbox"/> аэробик дасгал <input type="checkbox"/> биофеедбак <input type="checkbox"/> булчингийн хүчиний дасгал <input type="checkbox"/> тэнцвэрэйн дасгал <input type="checkbox"/> алхах дасгал <input type="checkbox"/> зохицолт хөдөлгөөний дасгал <input type="checkbox"/> үндсэн хөдөлгөөний <input type="checkbox"/> шилжих хөдөлгөн <input type="checkbox"/> бусад:( )		
	<input type="checkbox"/> физик эмчилгээ: <input type="checkbox"/> цахилган: <input type="checkbox"/> TES <input type="checkbox"/> TENS <input type="checkbox"/> FES <input type="checkbox"/> бусад <input type="checkbox"/> дулаан, гэрэл: <input type="checkbox"/> халуун жин <input type="checkbox"/> парафин <input type="checkbox"/> УВЧ <input type="checkbox"/> татлага: <input type="checkbox"/> хүзүү <input type="checkbox"/> ууц нуруу <input type="checkbox"/> усан эмчилгээ: <input type="checkbox"/> төрөл ( ) <input type="checkbox"/> бусад эмчилгээ:( )		
	<input type="checkbox"/> хөдөлмөр засал: <input type="checkbox"/> үйл ажиллагааны ходолмор засал <input type="checkbox"/> сэтгэл засал <input type="checkbox"/> танин мэдэхүйн дасгал <input type="checkbox"/> протез, ортез туслах хэрэгсэл <input type="checkbox"/> бусад:( )		
	<input type="checkbox"/> хэл яриа засал: <input type="checkbox"/> үйл ажиллагааны <input type="checkbox"/> харилцааны чадварын <input type="checkbox"/> сонсголын дасгал <input type="checkbox"/> залгуулах хооллох дасгал <input type="checkbox"/> бусад:( )		
	Өдөр тутмын үйл ажиллагаа (ADL):	?	Сэргээн засалтын агуулга (бодит эмчилгээний талаар бичих)
	хооллох шилжих угаалга бие засах усанд орох тэгш газар алхах шатаар өгсөх уруудах хувцаслах өтгөнөө хянах шингэнээ хянах		
харилцааны чадвар	оёлголт илэрхийлэлт		
сэргээн засах жор	<input type="checkbox"/> эмчилгээний хугацаа: .....оны.....сарын .....өдрөс .....оны .....сарын .....өдөр хүртэл <input type="checkbox"/> эмчилгээний давтамж: ( ) өдөрт/долоо хоногт <input type="checkbox"/> эмчилгээний цаг ( ) нэгж/өдөрт (20 минут нь 1 нэгж) <input type="checkbox"/> хөдөлгөөний эрчим: (зорилтолт зүрхний цохилтын тоо: ) <input type="checkbox"/> (Боргийн оноо: )		
сэргээн засах сувилахуй	<input type="checkbox"/>		
зөвлөгөө	<input type="checkbox"/> өвчний дахилтаас сэргийлэх <input type="checkbox"/> амьдралын хэв маяг өөрчлөх <input type="checkbox"/> бусад		
эмнэлгээ гарах	<input type="checkbox"/> гэртээ <input type="checkbox"/> өөр эмнэлэгт <input type="checkbox"/> сэргээн засах тасагт <input type="checkbox"/> сувилалд <input type="checkbox"/> бусад ( )		
гарах үеийн байдал	<input type="checkbox"/> алхаж <input type="checkbox"/> таягтай <input type="checkbox"/> тэргэнцэртэй <input type="checkbox"/> хэвтэрт <input type="checkbox"/> бусад: ( )		
сэргээн засах эмчилгээ үргэлжүүлэх шаардлагатай эсэх			
таниулах зөвлөхөөнөл	<input type="checkbox"/> тайлбар хийж зөвшөөрөл авсан: (гарын үсэг)..... он .....сар.....одор <input type="checkbox"/> тайлбар хийлгэж, хүлээн зөвшөөрсон : (үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн гарын үсэг)		
харьяа өрхийн	эмнэлэг	утас	эмчийн нэр